УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2019 оны 10 сарын 22 өдөр Дугаар А/332 Улаанбаатар хот

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай

Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Отгонбаатарын Оджаргал нь Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн Б/23 дугаар тушаалаар үүрэгт ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Ганболдын Билгүүнд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/47 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргын үүргийг хариуцуулсугай.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Үнэлгээний хороо /Д.Сүхбат/-нд даалгасугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/47 дугаар тушаалуудаар байгуулагдсан Үнэлгээний хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

D:\backup_old_pc\Work documents\УК 12\doc 2019\Тушаал doc.docx

1110301037